



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 21571

Хэрлэн сум

Хяналт тавих  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, 17.2.9 дахь заалтууд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, сангийн сайдын хамтарсан 2013 оны “Журам батлах тухай” А-96/71 дугаар тушаалаар батлагдсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион бйгуулах, санхүүжүүлэх, тарьмал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Улсын төсвийн хөрөнгөөр Хэнтий аймгийн Баян-Адарга суманд хийгдсэн байгалийн сэргэн ургалтанд туслах ажил, Ойн үрийн болон байнгын талбай тусгаарласан ажлын гүйцэтгэлд хяналт тавих, хүлээж авах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, Дадал суманд хийгдсэн байгалийн сэргэн ургалтанд туслах ажлын гүйцэтгэлд хяналт тавих, хүлээж авах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2. Хийгдсэн ажилд хяналт тавьж, хүлээж авах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж, холбогдох материалыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн (Б.Мөнхжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
дугаар сарын 10-ны өдрийн  
1571 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Мөнхжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Нарийн бичиг:	Б.Гүрсүрэн	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны мэргэжилтэн
Гишүүд:	Ш.Шинэбаяр	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөөгийн хөгжлийн хорооны гишүүн (Зөвшилцсөнөөр)
	Н.Анхбаяр	Баян-Адарга сумын Засаг даргын орлогч
	Б.Мөнхбаяр	Иргэний төлөөлөл, ахмад ойн инженер “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг Хэнтий аймагт хэрэгжүүлэх ажлын хэсгийн гишүүн



Аймгийн Засаг даргын 2023 оны  
..... дугаар сарын .....-ны өдрийн  
..... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

- |                       |              |   |
|-----------------------|--------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Б.Мөнхжаргал | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн                     |
| Нарийн бичиг:         | Б.Гүрсүрэн   | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны мэргэжилтэн   |
| Гишүүд:               | Ш.Шинэбаяр   | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөөгийн хөгжлийн хорооны гишүүн (Зөвшилцсөнөөр) |
|                       | Д.Гэрэлмаа   | Дадал сумын Засаг даргын Тамгын газрын дарга  |
|                       | Б.Мөнхбаяр   | Иргэний төлөөлөл, ахмад ойн инженер "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг Хэнтий аймагт хэрэгжүүлэх ажлын хэсгийн гишүүн             |